

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Тус компани нь гадаад дотоодын зочидод үйлчлэх 72 өрөө 150 ор бүхий зочид буудал, нэг ээлжиндээ Атланта ресторан 60-80, Хэрлэн паб 50-60 хүн хүлээн авах, мөн 15-20 хүн хүлээн авах кофе шоп, 7 өрөөтэй 10-45 хүн хүлээн авах караоке, нийт 21 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж байна.

Энэ хугацаанд компаний үйчилгээний чанар хүртээмжийг сайжруулан үйл ажиллагаагаа өргөжүүлэх, зах зээлд эзлэх хувь хэмжээ болон ашиг орлого нэмэгдүүлэх, ажиллагсадаа бүх талаар хөгжүүлэх, мэргэшүүлэхэд ихээхэн анхаарч ажилласан.

Тус аймагт албаны болон хувийн ажлаар ирэгсдийн судалгаа гаргаж тэдэнд үйлчлэх чанар хүртээмжийг дээшлүүлж, зочид буудлын үйлчилгээний тав тухыг нэмэгдүүлэх, зоогийн газрын хоол, үйлдвэрлэл үйлчилгээний чанар нэр төрлийг олшруулж сайжруулахад анхааран ажиллаж ирлээ.

Бид 2021 онд 4 сарын 19 өөс 5 сарын 13 хүртэл ковид өвчний ойрын хавилтын тусгаарлах байраар ажиллаж, 5-10 сарыг дуустал уул уурхай газрын тосны тусгаарлалт авж ажилсан. 9 сард үйл ажиллагаа явуулаагүй зочид буудлаараа нийт 1904 өрөөнд 2100 гадаад, дотоодын зочид хүлээн авч ажилласан.

2021 оны хагас жилээс 28-р байрныг их засварт оруулж 90% засварын ажил явагдаж байна. Мөн баруун жигүүртээ бүжгийн заалны засвар тогчилтын ажил явагдаж байна.

Мөн улсын баяр наадмыг угтаж компаний нийт ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор амралтанд амруулсан. 2021 оны 11 сард 4 ажилтан Түрк улсад аялуулж амруулсан.

2021 оны 4-р сарыг дуустал 28-р байранд 24 м.кв-т 6 өрх, 16 м.кв-т 31 өрх, 12 м.кв-т 18 айл, нийт 55 өрх түрээслэн суудаг. 2021 оны 12 сарыг дуустал 27-р байранд 24 м.кв-т 12 өрх, 16 м.кв-т 58 өрх, 12 м.кв-т 36 айл, нийт 106 өрх түрээслэн суудаг. Энэ онд нийт 161 айл өрхийн жилийн түрээсийн төлбөр 179605100 төгрөг орхоос 145345500 төгрөг төлөгдөж, 34259600 төгрөгийн авлагатай байна.

Тус компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд аймаг орон нутаг болон ажилчдынхаа ар гэр, эрүүл мэнд, компанийн орон сууцанд түрээсээр амьдарч буй ахмадууд, хүүхдүүдэд уламжлалт баяраар тодорхой хэмжээний хандив тусламж үзүүлж ажилласан.

Цаашид ажилчдынхаа ур чадварыг дээшлүүлэх зорилгоор чиглэл, чиглэлд нь сургалтанд хамруулж чадваржуулна.

2021 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын жагсаалт

№	Тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалт, засвар	Гүйцэтгэл /мян.төг/	Эзлэх хувь
1	Зочид буудлын зүүн гуяны 28-р байрид цонх-82, хаалга-56, цахилгаан, сан, барилгын засвар бүтэн хийгдэж байна. Тагтны 5 цонх солисон.	302,636.9	77%
2	Зочид буудлын мини маркетын лангуу, хөргөгч, кассын ширээ, цонх бүрэн шинчилсэн.	17,100.0	4,3%
3	Зочид буудлын 72 өрөөний 150 оронд цагаан хэрэглэл алчуурын шинчлэлт хийсэн.	34,446.0	8,6%
4	Рестораны шилэн хэрэглэлүүдийг солисон.	3,450.0	1%
5	Зочид буудлын өрөөны тв , тоос сорогч, ус буцалгагч, угаалгын машин	5,923.8	1,5%
6	Компьютер-3, притер-2 шинчилсэн	5,091.0	1,3%
7	Питнэсс клубд төөхөөрөмж суурьлуулсан	24,650.0	6,3%
	Нийт	393,297.7	100%

2022 онд хийгдэх ажлууд:


- Орон сууцны 27-р байры 4-5 давхарын 18 айлд их засвар хийж 12 айлын орон сууц болгон засварлана.
- Баруун жигүүрийн 3 давхарт нийтийн караоке 30-40 хүний багатаамжтай хийж тохижуулан их засвар хийнэ.

- Зочид буудалын 4 ортой энгийн өрөөг 2 ортой хагас люкес болгон засварлаж, иж бүрэн тавилга шинээр тавигна.
- 4, 5 давхарын цонхоны хөшиг шинчилж солино.
- Зочид буудалын өрөөний вакум цонх засвар үйлчилгээнд хамрагдана.
- Зочид буудалын 1 ортой болон 2 ортой өрөөнүүдэд урсгал засвар хийнэ.

Эдгээр ажлуудыг төлөвлөөд эхнээс нь хэрэгжүүлээд явж байна.

2021 оны орлогын бүтэц /мян.төг/

Д/Д	Үзүүлэлт	2021 гүйцэтгэл	Нийт орлогод эзлэх хувь
1	Үйл ажиллагааны орлого	1,009,064.5	100%
1.1	Байр орон сууцны түрээс	152,976.7	15,1%
1.2	Дэлгүүр	7,870.3	0.8%
1.3	Буудлын ор хоног	453,550.0	44.9%
1.4	Ресторан	385,312.5	38.2%
1.5	Кофе шоп	1,235.0	0.2%
1.6	Караоке	8,120.0	0.8%

Тайлан бичсэн: Нягтлан бодогч  Э. Лхагважаргал

